



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн  
Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар  
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, "Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/55 дугаар тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн  
дарга

-Цагдаагийн ерөнхий газрын дарга

Гишүүд:

-Төрийн албаны төв байгууллагын төлөөлөл  
-Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга  
-Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга  
-Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга  
-Захиргааны удирдлагын газрын дарга  
-Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга  
-Хуулийн хэлтсийн дарга

Салбар зөвлөлийн  
нарийн бичгийн дарга

Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Төрийн албаны зөвлөлийн тус Газрын дэргэдэх Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлэх, албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг гишүүн С.Цэдэндамбад тус тус даалгасугай.

3. Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл /Ө.Энхтөр/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 3 дахь хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 3 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 41 дүгээр тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 58 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 140 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

